

APU COMPANY

Absolute. Pure. Unique.

АПУ ХУВЬЦААТ КОМПАНИ

Улаанбаатар хот - 17040,
Чингисийн өргөн чөлөө - 14,
Утас: +976 - 11 - 342418
Факс: +976 - 11 - 343063
info@apu.mn, www.apu.mn

2020.04.06 № 01/285
танай _____ -ны № _____ -т

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
БИРЖ ТӨХК-Д

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Дэлхий нийтэд өндөр хурдацтай тархаж байгаа “COVID-19”-ын цар тахалтай тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 102 тоот тогтоолоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл сунгахаар шийдвэрлэсэн билээ.

Иймд үүсээд буй нөхцөл байдалд нийцүүлэн АПУ ХК-ийн зүгээс хувьцаа эзэмшигчдийг нэг дор олноор цуглуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг товлосон хугацаанд буюу 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 14:00 цагт цахим хэлбэрээр зохион байгуулахаар болсныг үүгээр мэдэгдэж байна.

Хурлын шинэчлэгдсэн зарыг өөрийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэж өгөхийг та бүхнээс хичээнгүйлэн хүсье.

Хавсралт: 1 хуудастай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Ч.АРИУНСАН

0000000074

АПУ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 102 тоот тогтоолоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал **2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 14:00 цагт** цахимаар явагдах болсныг мэдэгдэж байна.

Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:

1. АПУ ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гарах бүртгэлийн өдөр: **2020 оны 03 дугаар сарын 23-ны өдөр**

Хувьцаа эзэмшигч Та бүхэн хуралд оролцохын тулд:

1. Компанийн www.apu.mn вэб сайтаар нэвтрэн орж бүртгүүлнэ. Цахимаар бүртгүүлэх хугацаа **2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 00:00 цагт** дуусна. Хуралд бүртгүүлсэн хувьцаа эзэмшигчдэд хурлын холбоос, нууц үг, хуралд оролцох, санал өгөх зааварчилгааг бүртгэгдсэн цахим шуудангаар тусгайлан хүргүүлнэ.
2. Брокер дилерийн компаниудаар дамжуулан санал авах хуудсаар саналаа урьдчилж өгөх боломжтой. Санал авах хуудсаар санал авах хугацаа 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 13:00 цагт дуусна.

Хурлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хурал зохион байгуулах комиссын утас, цахим хаягаар холбоо барьж авна уу.

№	Нэрс	Утас	Цахим хаяг
1	Ч.Ариунсан	344336-338	agm2020@apu.mn
2	Б.Эрдэнэтуяа	344336-432	
3	Э.Солонго	344837-321	
4	Б.Бэгзсүрэн	344336-314	

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС